

OPENING STATEMENT OF MINISTER B.JARGALSAIKHAN AT THE LIGHT INDUSTRY SECTOR CONFERENCE

Honorable Guests,
Ladies and Gentlemen,

I would like to welcome you all to the Light Industry Sector Conference and wish to express my appreciation for your interest in investing and doing business in Mongolia.

It is my pleasure to note that this Conference is being held during the 800 year anniversary of Mongolia's Statehood.

I would like to take this opportunity to thank FIFTA, Euromoney Conference, and Bank of Mongolia for all their efforts in organizing this conference.

Ladies and Gentlemen:

It has been 16 years since Mongolia started its transition to a market economy. I am delighted to note that today Mongolia enjoys a matured democracy, stable political environment, and one of the most liberal economies in the world.

Stabilizing the macro economic environment, undertaking economic reforms by promoting private sector based export oriented economy and maintaining economic growth have been the major objectives of the Government.

The government of Mongolia gives special importance to increasing export oriented production in the processing of animal originated raw materials, mineral resources; developing information technology and promoting tourism.

Major improvements were made in social and economic areas as a result of the systematic measures taken by the government.

The government operates a favorable foreign investment policy, and as a result foreign direct investment has increased significantly with notable social and economic impacts. Foreign direct investment has increased to between USD 200 – 300 million annually, compared to USD 30-40 million annually in 1995 and 1996.

The majority or 47.7% of the of the total foreign direct investment is in the mining sector, followed by 15.4% in retail and catering sectors, 6% in the light industry sector, 5.3% in banking and financial sectors, 3.9% in the construction sector, and 3.8% in animal originated raw material processing industry.

In the foreseeable future, foreign investment would play an increasingly important role in maintaining economic growth and implementing government agenda.

Mongolia's social and economic development is mainly dependant on utilization of mineral resources. Other main sectors of the Mongolian economy are animal farming and agriculture.

I would like to summarize the opportunities available in the above mentioned sectors.

Mongolia is rich in cashmere which is sought after as a luxury product. The head count of goats reached 13.3 million in 2005, and annual cashmere production has reached approximately 3500 tons. Combed cashmere and knitted products meet international standards, and in product groups with international quality marked products. Mongolian cashmere is differentiated with its longer and narrower feature. It has more demand in European markets, as the longer and darker raw cashmere is more suitable for luxury goods.

In relation to increase in demand for cashmere products in the international market, Mongolia's cashmere processing industry is growing into a strategic sector with significant impact in Mongolia's export regime.

In the wool processing industry, 45 foreign and domestically owned factories and business entities operate in this sector. More than 40% of the factories do primary processing of wool and around 60% of the factories produce consumer goods such as carpet, blanket, felt and felt shoe, and floor covering etc.

In the leather industry raw material production capacity in 2005 was around 6.5 million count of hides and skin. 50.8% or 3.3million of the total is sheep skin, 36.9% or 2.4 million is goat skin, 6.5% or 0.42 million is cow hide, 4.9% or 0.32 million is horse hide, the rest is other animal skin.

In the textile industry about 100 business entities are operating, of which 38.3% or 36 are established with 100% foreign direct investment, 46.8% or 44 are joint companies and 14.9% or 14 are domestically owned companies. Textiles industry employs more than 20 thousand workers, which is about 17.5% of the total employment in industrial sector. This sector produces 5% of industrial goods, and exports 10% of the total export (the calculation of the businesses does not add up).

The great significance accorded the textile industry is evident in the tax exemptions that raw materials, in-process materials and other basic and supplementary materials as well as equipments used in this sector enjoy under the import duties and VAT Law.

Currently there are more than 150 entities operating in the timber processing sector, of which 40 were established with foreign direct investment.

Ladies and gentlemen, allow me to expound the Government's goals and objectives.

It is clear that without bringing up the current level of FDI and increasing the production capacity, Mongolia will not be able to compete on the world market. In this regard, the Government of Mongolia has been working to direct Foreign Investment onto a certain track by drafting policies and getting them approved by the Parliament.

The Government of Mongolia attaches great importance to the sustainable development of its industrial base, and in order to achieve this goal it has been putting more emphasis on the establishment and development of industrial and technological parks.

The intention is to improve Mongolia's competitive position in today's globalizing world. Since more exports will allow us to have a self-sustaining economy.

Currently, there are 4 towns which are included in the framework of the "General guide or principle for the development of Industrial and Technological Parks". In specific, Ulaanbaatar, Darkhan, Erdenet and Baganuur are for establishing and developing Industrial and Technological Parks, which are mainly to deal with processing animal derived products and making end use products.

Through the implementation of this project we could create 31,000 new jobs, produce goods worth 330 million USD, and this would have both a direct and indirect effect on about 200,000 people.

In addition, a feasibility study on utilizing wood and timber for producing final products in Darkhan is being undertaken.

We are now also drafting laws and procedures for regulating the activities within the technological parks and investors who will be running their activities in the parks will be covered under the special tax relief program.

Ladies and gentlemen, dear investors;

I recommend you to study the "General guide for the development of Industrial and Technological Parks", in which every condition such as the potential, resources of every location has been taken into account. We will be happy to assist and cooperate with you on this matter.

Parliament has recently approved a law on leasing, which is a big step in supporting businessmen. Leasing services will enable those engaged in the processing industry to revamp their machinery and equipment.

Ladies and Gentlemen:

One of the major actions undertaken during the transition period was the process of liberalizing trade for achieving greater economic growth by eliminating monopolies and bringing import tariffs down to 5%. Mongolia has one of the lowest tariffs among other developing countries, which shows its strong commitment to the liberalization process.

In March 2005, our trade policy regime was reviewed by the membership of the WTO and assessed with praise in terms of investment and trade policies reforms undertaken by the Government.

Mongolia has been granted special trading preferences by countries such as the USA, Canada, EU and Japan. These preferences have been encouraging to our producers and exporters. Inclusion of Mongolia in the GSP Plus Scheme provides the producers and exporters with access to a vast European market, which is ready to absorb around 7200 duty free items.

One of the major constraints for efficient trade is our landlocked location. However, a tripartite transit framework agreement between Russia, China and Mongolia gives us a slight improvement in dealing with the abovementioned barrier. Although the general text of the agreement has been agreed by the parties we still need to negotiate on the annexes.

Ladies and Gentlemen,

In its agenda, Government of Mongolia has identified light industry sector as one of the priority sectors for economic development and it encourages foreign direct investment in this sector.

I deeply believe that your investment in Mongolia will foster your business, while contributing to Mongolia's social and economic development.

I announce that the Light industry Investors' conference is now officially in session.

Welcome to Mongolia. I hope you will take this opportunity to closely explore Mongolia.

Thank you for your attention.

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Б.ЖАРГАЛСАЙХАНЫ
ХӨНГӨН АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР ХУРАЛДААНЫГ
НЭЭЖ ХЭЛЭХ ҮГ**

**Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө,
Ноёд , хатагтай нараа!**

Юуны өмнө Монгол орныг сонирхож хөрөнгө оруулах боломжийг судлан Монголд бизнес эрхлэх сэтгэл өвөрлөн энэхүү чуулга уулзалтад хүрэлцэн ирсэн зочид, төлөөлөгчид та бүгдэд Монгол улсын Үйлдвэр, худалдааны сайдын хувьд мэндчилгээ дэвшүүлж, чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Энэхүү чуулга уулзалт нь Их Монгол Улсын байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх жилтэй давхцан тохиож байгааг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Энэ боломжийг ашиглан чуулга уулзалтын бэлтгэлийг хангах, зохион байгуулах ажлыг амжилттай хийсэн Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газар, Евромани конференцс, Монгол банкинд талархаж буйгаа илэрхийлье.

Ноёд , хатагтай нараа !

Монгол улс зах зээлийн тогтолцоонд шилжиж, эдийн засгийн гадаад харилцаанд нээлттэй бодлого явуулж эхэлснээс хойш эдүгээ 16 жилийн хугацаа өнгөрч байна. Монгол орон өнөөдөр ардчилал шинэчлэлийн замаар замнаж байгаа, эдийн засаг нь улам бүр либералчилагдаж байгаа, улс төрийн хувьд тогтвортой, байгалийн баялагаар арвин орон гэдгийг хэлэхэд хэлэхэд таатай байна.

Засгийн газар макро эдийн засгийг тогтворжуулах, хувийн хэвшилд тулгуурласан экспортын чиг баримжаатай эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж, эдийн засгийн өсөлтийг хангах зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж ирлээ.

Уул уурхай, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулж, экспортын чиг хандлагатай үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мэдээлэл, холбооны технологи, дэд бүтэц, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд Засгийн газар тэргүүлэх ач холбогдол өгч байна.

Монгол улсын Засгийн газраас өнгөрсөн жилүүдэд дэс дараатай олон арга хэмжээ тууштай авч хэрэгжүүлсний дүнд эдийн засаг, нийгмийн хөгжлийн салбарт тодорхой үр дүн гарч, эдийн засгийн багагүй өсөлтөнд хүрлээ.

Монгол Улсын төр, засгаас гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн тууштай бодлогын үр дүнд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, түүний нийгэм, эдийн засгийн үр нөлөө мэдэгдэхүйц болж ирлээ. 1995-96 оны түвшинд жилдээ 30-40 сая орчим ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт бүртгэгдэж байсан бол эдүгээ зөвхөн нэг жилд 200-300 сая ам.долларын хөрөнгө оруулалт орох болсон байна. Тухайлбал, 2004 онд 237 сая ам. долларын, 2005 онд 311 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг салбаруудаар авч үзвэл геологи хайгуул, уул уурхай, газрын тосны салбарт хамгийн их буюу нийт хөрөнгө оруулалтын 47,7 хувь, худалдаа, нийтийн хоолны салбарт 15,4%, хөнгөн үйлдвэрт 6%, банк санхүүгийн үйл ажиллагаанд 5,3%, барилгын үйлдвэрлэлд 3,9%, малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтанд 3,8% орсон байна.

Цаашдаа тогтвортой өсөлтийг хангаж, өмнө тавьсан зорилтуудаа хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтын асуудал нэн чухлаар тавигдаж байна.

Манай орны нийгэм, эдийн засгийн хөгжил нь байгалийн баялагийн нөөцийн ашиглалтаас өргөн хамааралтай бөгөөд байгаль цаг агаараас шууд хамааралтай нүүдлийн бэлчээрийн мал аж ахуй болон газар тариалан хөдөө аж ахуйд давамгайлж, байгалийн төрөл бүрийн баялгийн нөөцийг олборлох салбар аж үйлдвэрт зонхилж байна.

Би та бүхэнд энэхүү салбарт ямар нөөц, бололцоо байгаа талаар цөөн үгээр мэдээлэл өгье.

Тансаг бүтээгдэхүүний түүхий эд болох ноолуурын нөөцөөр баялаг орны тоонд манай улс зүй ёсоор багтдаг.

Монгол улсын ямаан сүргийн тоо толгой 2005 онд 13.3 саяд хүрч ноолуур бэлтгэлийн жилийн нөөц 3500 орчим тонн болоод байна.

Самнасан ноолуур, сүлжмэлийн чанар нь дэлхийн зах зээлийн хэрэгцээг хангахаас гадна олон улсын чанарын тэмдэгтэй бүтээгдэхүүний тоонд багтдаг. Монгол ноолуурын ялгарах онцлог, давуу тал нь түүний уртлаг, нарийн чанар юм. Урт, бараан ноолуураар тансаг бүтээгдэхүүн хийхэд ихээхэн тохиромжтой тул Европын орнууд худалдаж авах сонирхол ихтэй байдаг.

Дэлхийн зах зээлд ноолууран бүтээгдэхүүний хэрэгцээ өссөнтэй уялдан манай улсын ноолуур боловсруулах үйлдвэрлэл нь экспортод чухал нөлөө бүхий стратегийн ач холбогдолтой салбар болон хөгжиж байна.

Ноосны хувьд хонь, тэмээ, ямааны ноос, сарлагийн хөөвөр, арьс ширний үйлдвэрлэлээс гардаг хаягдал ноос, адуу, үхрийн хялгас зэрэг 10 гаруй төрлийн 20 гаруй мянган тонн ноос боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Үүний 70 гаруй хувийг хонины ноос, 2 орчим хувийг тэмээний ноос, үлдсэн хувийг сарлагийн хөөвөр, арьс ширний үйлдвэрлэлээс гарах хаягдал ноос, адуу, үхрийн хялгас эзэлдэг.

Ноос боловсруулах салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай 45 үйлдвэр, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Үүний 40 гаруй хувь нь анхан

шатны боловсруулалтын, 60 орчим хувь нь хивс, хөнжил, эсгий, эсгий гутал, зулхай, ширдэг зэрэг эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг.

Сарлагийн хөөвөр нь шинж чанарын хувьд ямааны ноолууртай төстэй, зөөлөн, богино ширхэгтэй түүхий эд. Жилд 300 гаруй тонн сарлагийн хөөвөр бэлтгэдэг бөгөөд 1990 оноос өмнө сарлагийн хөөврийг эсгий, эсгий гутлын үйлдвэрт ашиглаж байсан. Сүүлийн жилүүдэд сарлагийн хөөврөөр төрөл бүрийн сүлжмэл эдлэл үйлдвэрлэж байна.

Арьс, ширний хувьд 2005 оны байдлаар 6,5 сая ширхэг арьс, ширэн түүхий эд бэлтгэх нөөцтэй байна. Үүний 50,8 хувь буюу 3,3 сая ширхэгийг хонины арьс, 36,9 хувь буюу 2,4 сая ширхэгийг ямааны арьс, 6,5 хувь буюу 0,42 сая ширхэгийг үхрийн шир, 4,9 хувь буюу 0,32 сая ширхэгийг адуу, 0,9 хувийг бусад төрлийн арьс ширэн түүхий эд эзэлж байна.

Өнөөгийн байдлаар оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт 100 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн 38.3 хувь буюу 36 нь гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай, 46.8 хувь буюу 44 нь хамтарсан хөрөнгө оруулалттай, 14.9 хувь буюу 14 нь дотоодын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүд юм. Дээрх үйлдвэрүүдэд 20 гаруй мянган хүн ажиллаж байгаа нь аж үйлдвэрийн салбарт ажиллагсадын 17.5 хувийг эзэлж байна. Тус салбар нь манай аж үйлдвэрийн салбарын 5, экспортын орлогын 10 орчим хувийг эзэлж байна.

Бид энэ салбарт онцгой ач холбогдол өгч “Зарим бараа, бүтээгдэхүүнийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хууль гарган хэрэгжүүлж эхлээд байна. Энэ хуулиар оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн зориулалттай түүхий эд, үндсэн ба туслах материал, сэлбэг хэрэгслэлийг гаалийн болон нэмэгдсэн албан татвараас чөлөөлж байна.

Мод боловсруулах салбарын хувьд өнөөгийн байдлаар жижиг, дунд хэмжээний 150 гаруй компани үйл ажиллагаа явуулж байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай 40 орчим компани ажиллаж байна.

Модон бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээ сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж байгаагийн үндсэн гол нөлөөлөх хүчин зүйл нь барилгын салбарын өсөлттэй шууд холбоотой бөгөөд барилгын хаалга, цонхны үйлдвэрлэлт өссөөр байна.

Одоо бид ямар зорилго тавьж буй талаар ярилцая.

Цаашид хөрөнгө оруулалтыг шинэ түвшинд гаргаж, үйлдвэрлэлийг эрчимжүүлэхгүйгээр Монгол улсын өрсөлдөх чадварыг хангах бололцоо байхгүй нь ойлгомжтой. Энэ зорилгоор Монгол улсын Засгийн газраас хөрөнгө оруулалтыг тодорхой зорилгод чиглүүлэх үүднээс бодлогын чанартай баримт бичгүүдийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулан хэрэгжүүлж байна.

Засгийн газрын үйл ажиллагаа нь экспортын баримжаатай үйлдвэрлэл болон жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулах, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэгдэж байна.

Эдийн засгийн өсөлтийг хангахад аж үйлдвэрийг тууштай хөгжүүлэх асуудал ихээхэн чухал бөгөөд Засгийн газрын анхаарлын төвд байсаар байна. Үүнийг шийдвэрлэхэд үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, хөгжүүлэх асуудал чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Үйлдвэр, технологийн парк байгуулж, хөгжүүлснээр даяарчлагдсан дэлхий ертөнцөд Монгол улсын ирээдүйн хөгжил, дэвшлийг хангах экспортын чиглэлтэй эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийн бүтэц бий болох юм. Экспортын хэмжээ нэмэгдэж, эдийн засаг өөрийгөө тэтгэн хөгжих боломж бүрдсэнээр дэлхийн зах зээлд тодорхой нэрийн бүтээгдэхүүнээр өөрийн байр суурийг эзлэх боломж бүрдэнэ. Үйлдвэрлэлийн хөгжлийг даган дэд бүтэц, үйлчилгээний тогтолцоо эрс сайжирч, ажил эрхлэлт нэмэгдэн, хүн амын амьжиргааны түвшин дээшлэн, орчин үеийн технологи, менежмент нэвтэрч, үндэсний боловсон хүчний чадавхи ахих зэрэг олон талын эерэг үр дүн гарах юм.

“Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд одоогийн байдлаар Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд болон Багануур дүүрэгт мал аж ахуйн гаралтай түүхий эдийг гүн боловсруулж, экспортын зориулалттай нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрүүдийг багтаасан үйлдвэрлэл, технологийн парк байгуулахаар төлөвлөж, холбогдох тооцоо, судалгааны ажил хийж эхлээд байна.

Бид дээрх хотуудад бог, бод малын арьс, шир болон ямааны ноолуур, хонь, тэмээний ноос зэрэг мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бүрэн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цогцолборууд байгуулах бөгөөд энэхүү төсөл хэрэгжсэнээр 31 мянга гаруй ажлын байр шинээр бий болж, 330 гаруй сая ам.долларын бүтээгдэхүүн экспортлох боломжтой болж, улмаар шууд болон шууд бусаар 200 мянга гаруй хүний амьжиргааны эх үүсвэрийг бий болгоно гэж тооцоолж байна.

Үүний зэрэгцээ Дархан хотод модон түүхий эдийг иж бүрэн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цогцолбор байгуулахаар холбогдох судалгаа, төсөл боловсруулаад байна.

Үйлдвэрлэл, технологийн парк байгуулахын тулд төрөөс газрын төлбөрийн хэмжээг тогтоож, хөнгөлөлт үзүүлэх, парк байгуулах төлөвлөгөө, төсөл боловсруулах ажлыг зохион байгуулж, зарим талын санхүүгийн дэмжлэг үзүүлэх, паркт өндөр мэргэшлийн гадаад, дотоодын менежер, мэргэжилтэн ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх зэрэгт анхаарч байна. Парк байгуулах үүсгэл санаачлага гаргасан аж ахуйн нэгжийг тэргүүн ээлжинд гадаад орон, олон улсын хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулахаар төлөвлөж байна.

Паркт үйл ажиллагаа эрхлэх хөрөнгө оруулагчид нь татварын онцгой хөнгөлөлт эдлэх бөгөөд паркийн үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхээр холбогдох хуулийн төсөл, журам боловсруулах ажлыг Засгийн газраар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Иймээс хот, дүүргүүдийн нөөц, боломж, онцлогийг харгалзан хаана ямар төрлийн парк байгуулахыг тодорхойлсон “Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, хөгжүүлэх үндсэн чиглэл”-тэй нарийвчлан танилцахыг Та бүхнээс хүсч байна. Эндээс илүү их мэдээлэл авах боломж бий. Сонирхсон хөрөнгө оруулагч энэ хүрээнд бидэнтэй хамтран ажиллах боломж байгаа гэдгийг хэлье.

УИХ-аас “Лизингийн тухай хууль”-ийг батлан гаргасан нь бизнес эрхлэгчдийг дэмжих томоохон алхам болсоныг дурдах хэрэгтэй. Тэр дундаа лизингийн үйлчилгээ нь боловсруулах салбарын үйлдвэрүүдэд тоног, төхөөрөмжийн шинэчлэл хийх гол үндэс болох юм. Энэ салбарт та бүхэнд хамтран ажиллах боломж мөн байна.

Ноёд, хатагтай нараа !

Шилжилтийн үед хийсэн хамгийн чухал алхмуудын нэг нь эдийн засгийн өсөлтийг хангахад худалдааны үзүүлэх нөлөөг харгалзан худалдааг либералчилсан явдал юм. Худалдааны монопольлолыг арилгаж, импортын тарифыг ихэнх бараанд 5 хувь хүртэл бууруулсан. Монгол Улс нь хөгжиж байгаа орнуудын дотор хамгийн бага импортын тарифтай оронд тооцогдож байгаа нь худалдаа бараг бүрэн либералчлагдсаныг харуулж байна.

Өнгөрсөн оны 3 дугаар сард Женев хотноо ДХБ-ын гишүүн орнууд манай худалдааны бодлогыг дүгнэн хэлэлцсэний дүнд Монгол улс худалдаа, хөрөнгө оруулалтын талаар харьцангуй либераль бодлого баримталж байгааг хүлээн зөвшөөрч, сайн үнэлгээ өгсөнийг энд бас нэмж хэлмээр байна.

Монгол улс хөгжиж байгаа орны хувьд худалдааны хөнгөлөлттэй нөхцөл эдэлдэг. АНУ, Канад, ЕХ, Япон Улс нь манай улсыг хөнгөлөлтийн ерөнхий системдээ хамруулсан нь экспортыг нэмэгдүүлэхэд ихээхэн дэмжлэг үзүүлж, үндэсний үйлдвэрлэлийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Мөн өнгөрсөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн ЕХ-ны тарифын хөнгөлөлтийн “GSP+” хөтөлбөрт хамрагдсан нь манай улсын хувьд 7200 орчим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн Европын Холбооны зах зээлд гаалийн татваргүйгээр гарах өргөн боломжийг нээж өглөө.

Хөрөнгө оруулагчийн гол сонирхдог нөхцөл болох тээвэрлэлтийн зардал нь Монголын өргөн уудам газар нутаг, газарзүйн байрлал, далайд гарцгүй зэргээс шалтгаалан онцгой анхаарах асуудлын нэг болоод байна. Энэ чиглэлд зарим ахиц гарч, ОХУ, БНХАУ-тай дамжин өнгөрөх тээврийн асуудлаар 3 талын хэлэлцээр байгуулахаар ажиллаж, хэлэлцээрийн үндсэн нөхцлийг тохиролцоод байна.

Ноёд, хатагтай нараа !

Хөнгөн аж үйлдвэрийн салбар нь Монгол улсын Засгийн газраас баримтлах тэргүүлэх чиглэлд хамрагддагийн хувьд бид бүхэн ихээхэн анхаарал тавьж ажиллах бөгөөд та бүхнийг энэ салбарт хөрөнгө оруулалт хийхийг хүсч байна. Дээр хэлсэнчлэн бидэнд маш их боломж бий. Хамгийн гол нь итгэлцэл дээр тулгуурласан харилцан хамтын ажиллагаа нэн чухлаар тавигдаж байна.

Манай оронд хөрөнгө оруулалт хийж, бизнесийнхээ үр ашгийг нэмэгдүүлэн Монгол улсын эдийн засгийн хөгжил, дэвшилд бодит хувь нэмрээ оруулах сонголт хийнэ хэмээн Та бүхэнд бид итгэж байна

Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын Хөнгөн үйлдвэрийн салбарын хуралдааны үйл ажиллагаа үүгээр нээснийг мэдэгдье.

Та бүхэн Монгол нутагт тавтай морилж, энэ боломжийг ашиглан Монгол оронтой ойртон танилцаарай.

Анхаарал тавьсанд баярлалаа.